

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын гэрчилгээ .....	2
Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12 Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал .....	10
Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
З.МЭНДСАЙХАН ТАНАА

2020.02.21 № 06/598  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.1 Оршил

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга З.Мэндсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн урьдчилж олсон орлого, авлага, үндсэн хөрөнгө, өглөг, зардлын данстай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин хариуцаж хэрэгжүүлэв.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А-1/107 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь “Төрийн өмчийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх удирдлагыг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн

этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэн, ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангахад оршино” хэмээн зорилго тодорхойлон дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохицуулалтаар хангах;
- Төрийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих;
- Худалдан авах ажиллагааг төлөвлөн, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах;
- Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа тул санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 3.0” программ хангамж ашигладаг байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болох нийт орлого 153,029,893.0 мянган төгрөгийн 1 хувиар тооцож 1,530,298.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувиар буюу 1,599,541.2 мянган төгрөгөөр тодорхойлов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,599,541.2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн тайлан бэлтгэгдээгүй байсантай холбоотой болно.

## 2.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,238.4 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	988,839.5	1,043,845.0	55,005.5
Үндсэн хөрөнгө	5,004,324.2	5,058,557.1	54,232.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,993,163.7</b>	<b>6,102,402.1</b>	<b>109,238.4</b>
Өр төлбөр	988,039.5	1,043,845.0	55,805.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,005,124.2	5,058,557.1	53,432.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,993,163.7</b>	<b>6,102,402.1</b>	<b>109,238.4</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 55,005.5 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гурвалсан гэрээний дагуу байршуулсан түрээсийн барьцаа хөрөнгө өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь өмнөх онд худалдаж авсан 246,476.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 49,750.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 296,226.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Төрийн өмчийг түрээсэлж буй иргэн, аж ахуй нэгжийн түрээсийн барьцаа хөрөнгө өссөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,058,557.1 мянган төгрөг болж 53,432.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тайлант онд Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг 310,800,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 155,232,194.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 49.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг	310,800,000.0	155,232,194.8	155,567,805.2	49.9
Үүнээс: Ирээдүйн өв санд	300,800,000.0	151,568,566.3	149,231,433.7	50.4
Улсын төсөвт	10,000,000.0	3,663,628.5	6,336,371.5	36.6

Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг 155,567,805.2 мянган төгрөгөөр тасарсан нь:

- Засгийн газрын 2019 оны 4 сарын 10-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр “Эрдэнэс таван толгой” ХК-ын ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болгосон, “Эрдэнэс Монгол”ХХК, “Багануур” ХК Улсын төсөвт ноогдол ашгийн орлого төвлөрүүлэх боломжгүй зэрэг шалтгаанаар “Ирээдүйн өв сан”-д төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 149,231,433.7 мянган төгрөгөөр тасарсан,
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 сарын 21 өдрийн 229 дүгээр тогтоолоор Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг 11,172,648.1 мянган төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас 3,663,628.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь "МИАТ" ХК 7,335,111.6 мянган, "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" ТӨҮГ 59,621.3 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан урсгал зардалд 1,505,074.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Нийт зардлын 1,500,074.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 1,464,145.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 46,876.5 мянган төгрөг, нийт 1,511,022.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 1,463,812.1 мянган төгрөгийг зарцуулж 47,210.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт төсвийн дансанд Сангийн сайдын 2019 оны 251 тоот тушаалаар үндсэн үйл ажиллагааны давсан орлого 121,000.0 мянган төгрөгийн санхүүжилт өгчээ. Үүнээс 7,841.2 мянган төгрөгийг урсгал өр төлбөрийг барагдуулахад, 40,538.6 мянган төгрөгийг тоног төхөөрөмж бэлтгэхэд, 72,600.0 мянган төгрөгийг ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэхэд зарцуулж, 20.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10 АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 8,807,981.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 467,544.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,398,344.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 595,480.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 346,611.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 8,340,437.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,398,344.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 595,480.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолоор баталсан Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг "МИАТ" ХК 7,335,111.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.1-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг" Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсын төсөвт 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай" гэж заасныг тус тус зөрчсөн, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолоор баталсан Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" ТӨҮГ 59,621.3 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.1-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг" Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсын төсөвт 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай" гэж заасныг тус тус зөрчсөн, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Тайлант онд Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний 10.2-т заасны дагуу түрээсийн гэрээг цуцлах хүсэлт гаргасан 3 аж ахуйн нэгж, байгууллагын түрээсийн барьцаа төлбөр 3,607.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас Улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний 10.2-т "Түрээслэгчийн санаачилгаар түрээсийн гэрээг хугацаа дуусахаас өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд түрээсийн барьцаа, түрээсийн төлбөрийг түрээслэгчид олгохгүй болно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. Хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа 595,480.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 503,077.7 мянган төгрөгийн элэгдэлтэй нийт 8 ширхэг авто тээврийн хэрэгслийг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.1.6-д "Балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

5. Өмнөх онд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2017 оны ноогдол ашгийг төвлөрүүлээгүй зөрчил илэрч 1,171,317.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсноос ТӨБЗГ-ын орлогын дансанд төвлөрсөн 171,317.6 мянган төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч үр дүнгийн тайланд тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

6. Өмнөх онд 49,750.0 мянган төгрөгийн программ хангамж, 14 нэр төрлийн 246,476.6 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж нийт 296,226.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд зардлаар бүргэж тайлагнасан бөгөөд тайлант онд дээрх үндсэн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн 346,611.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

## **2.12 Шилэн дансны мэдээлэл**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,171,317.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг Улсын төсөвт бүрэн төвлөрүүлж ажилласан байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

## **2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1. Авлага, урьдчилж олсон орлого данстай холбоотой асуудал**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гуравласан гэрээний дагуу төвлөрүүлсэн орлогоос илүү төлөлттэй 11,310.6 мянган төгрөгийг урьдчилж олсон орлогоор, дутуу төлөлттэй 64,951.8 мянган төгрөгийг авлагаар тус тус бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх,

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтлөх, авлага, урьдчилж олсон орлогыг УСНБОУС-ын дагуу бүртгэж байх; .

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.2. Авлагын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1. Илрүүлэлт:**

Харилцагч байгууллагатай 600.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" , 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### **3.2.2. Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглан залилан үүсэх;

#### **3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх, хөрөнгө, авлагыг орхигдуулахгүй бүртгэж байх;

#### **3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

#### **3.3.1. Илрүүлэлт:**

Үйл ажиллагааны давсан орлогоос нийт 40,538.6 мянган төгрөгийн 3 нэр төрлийн 17 ширхэг тоног төхөөрөмжийг худалдаж авахдаа шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" , 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### **3.3.2. Эрсдэл:**

Хөрөнгө дутагдах, ашиглан үүсэх, санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт алдагдах;

#### **3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах;

#### **3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.4 Өглөгийн данстай холбоотой асуудал**

#### **3.4.1. Илрүүлэлт:**

Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гуравласан гэрээний дагуу байршуулсан 1,043,845.0 мянган төгрөгийн түрээсийн барьцааны үлдэгдэлтэйгээс

2019.12.31-ний байдлаар 195,281.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, авлага, өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх;

#### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулж байх, ажил гүйлгээг тухай бүр нь нягтлан бодох бүртгэлд тусгаж байх;

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 3.5 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.5.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 33,928.9 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.20-д "Төсөвт байгууллага нь бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана", 4.21-т "Бараа материалыг худалдан авсан үед Дт. Хангамжийн материал Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 3.5.2 Эрсдэл:

Ажил гүйлгээг стандарт, журам, зааврын дагуу бүртгээгүй, санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх;

##### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг үнэн зөв бүртгэж тайлагнах, "Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөж ажиллах.

##### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	988,839,526.12	1,043,845,013.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	988,839,526.12	1,043,845,013.13
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	800,000.00	-
31110	Төгрөг	800,000.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	988,039,526.12	1,043,845,013.13
31210	Төгрөг	988,039,526.12	1,043,845,013.13
31211	Төрийн сангийн харилцах	988,039,526.12	1,043,845,013.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,004,324,221.54	5,058,557,109.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,004,324,221.54	5,058,557,109.88
39200	Биет хөрөнгө	3,523,141,821.54	3,527,624,709.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,026,142,380.00	3,026,142,380.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(71,344,622.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	774,244,249.40	954,256,805.51
39204	Хуримтлагдсан элэгдэл	(424,220,345.92)	(727,923,151.66)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	334,329,761.02	553,249,049.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(329,426,913.10)	(315,325,037.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	381,166,217.20	377,981,267.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(239,093,527.06)	(269,411,980.15)
39300	Биет бус хөрөнгө	1,481,182,400.00	1,530,932,400.00
39301	Програм хангамж	1,446,212,000.00	1,495,962,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө	35,960,400.00	35,960,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,993,163,747.66	6,102,402,123.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	988,039,526.12	1,043,845,013.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	988,039,526.12	1,043,845,013.13
41300	Өглөг	988,039,526.12	1,043,845,013.13
41360	Бусад өглөг	988,039,526.12	1,043,845,013.13
41361	Байгууллагад төлөх өглөг	988,039,526.12	1,043,845,013.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,005,124,221.54	5,058,557,109.88
51	Засгийн газрын хувь оролцоо	5,005,124,221.54	5,058,557,109.88
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	35,655,560.00	35,655,560.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,571,402,126.59	4,624,835,014.93
51210	Өмнөх үеийн үр дүн	21,728,887,766.63	4,867,628,726.59
51220	Тайлант үеийн үр дүн	(17,157,485,640.04)	(242,793,711.66)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,066,534.95	398,066,534.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,993,163,747.66	6,102,402,123.01

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	48,707,579,357.43	159,954,129,654.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,588,387,357.43	158,368,983,754.86
120	Нийтлэг татварын бус орлого	45,879,482,842.46	157,934,629,926.30
120001	Хувьцааны ногдол ашиг	43,234,798,159.59	155,232,194,792.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	675,925,140.31	46,876,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	285,837,163.50	46,876,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	390,087,976.81	-
120005	Түрээсийн орлого	1,968,759,542.56	2,384,772,879.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	270,785,754.21
121	Хөрөнгийн орлого	708,904,514.97	434,353,828.56
121002	Өмч хувьчлалын орлого	708,904,514.97	434,353,828.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,119,192,000.00	1,585,145,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,119,192,000.00	1,464,145,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,945,892,000.00	1,464,145,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	173,300,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	121,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	121,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	48,779,588,851.09	159,893,380,722.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,779,588,851.09	159,893,380,722.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,627,003,617.56	1,712,410,898.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,519,000.00	899,686,299.12
210101	Үндсэн цалин	606,623,600.00	680,730,900.00
210102	Нэмэгдэл	127,989,900.00	165,049,899.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,905,500.00	53,905,500.00
210104	Урамшуулал	1,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,622,300.00	110,214,254.69
210201	Тэтгэврийн даатгал	63,081,500.00	76,473,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,885,200.00	6,750,354.69
